



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/580

Номгон

“Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс  
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Монгол улсын “Эрүүл мэндийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/400 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа эрхлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга – Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга - Эрүүл мэндийн газрын Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн

Гишүүд

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомжийн системчлэл хариуцсан ахлах мэргэжилтэн

Ажлын албаны дарга бөгөөд Эрүүл мэндийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын Эмийн бодлогын мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Статистикч их эмч

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс нь Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7.1, 9.1 дэх заалтыг баримтлах, үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлага, өрсөлдөөнд нөлөөлөх

601210355


2.

байдлыг үнэлж, тодорхойлон тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг удирдлага, мэргэжлийн арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллан тайланг жил бүр Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Комиссын даргад үүрэг болгосугай.

3. Комиссын эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааны өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх ажлын албыг байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т хариуцуулсугай.

4. Энэхүү захирамж гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны "Комисс байгуулах тухай" А/684 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

5. Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН